



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ



“МГТБИМХ”

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2023 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

№...СБ-2023/01.

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү хамтран ажиллах санамж бичиг /цаашид “Санамж бичиг” гэх/-ийг Нэг талаас “Монголын төмөр зам” ТӨХК, нөгөө талаас “Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо” нар стратегийн томоохон орд газруудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, бус нутгийг хямд өртөг бүхий шатахуунаар хангах, шатахуун тээвэрлэхтэй холбоотой хөрсний бохирдлыг багасгах, байгаль орчинд үүсэж болох сөрөг нөлөөллийг бууруулах, төмөр замын тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор байгуулав.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

2.1 Талууд дараах хүрээнд хамтран ажиллана. Үүнд:

2.1.1.1 Хамтын ажиллагааны хүрээнд “Тавантолгой-Зүүнбаян” Чиглэлийн төмөр замаар шатахуун тээвэрлэлтийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах.

2.1.1.2 Талууд хамтын ажиллагаанд Монгол Улсын иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Төмөр замын нийтлэг багц дүрэм, стандартыг баримтлах.

2.1.1.3 Төмөр замын тээвэрлэлт, ачилт буулгалтын ажиллагааг оновчтой зохион байгуулж вагон эргэлт, ачаа хүргэх хугацааг хурдаасгах.

2.1.1.4 Талуудаас зохион байгуулсан арга хэмжээ, үйл ажиллагааг 2 талаас эрхлэн гаргадаг /хамтран ажиллах тэрээ бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэл/ сонин, сэтгүүл болон холбогдох цахим хуудас, телевиз, радиогоор олон нийтэд сурталчлан таниулах.

ГУРАВ. БУСАД

3.1. Талууд санамж бичигт дурдсан ажлыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлнэ.



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ



"МТСБИМХ"

3.2 Талууд цаашдын хамтын ажиллагааны үндэс болох энэхүү санамж бичигт гарын үсэг зурснаар аливаа санхүүгийн болон бусад хариуцлага хүлээхгүй болно.


3.3. Санамж бичгийн хүрээнд талууд шаардлагатай мэдээллийг харилцан солилцож хамтран ажиллана.

САНАМЖ БИЧГИЙГ БАЙГУУЛСАН:

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



"МОНГОЛЫН ГАЗРЫН ТОСНЫ
БҮТЭЭГДЭХҮҮН ИМПОРТЛОГЧДЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО"-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ГАЗРЫН
АХЛАХ МЕНЕЖЕР

Б. УУГАНХҮҮ

ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ
МЕНЕЖЕР

Г.ШИЖИРБААТАР

АЧАА ТЭЭВРИЙН
АЛБАНЫ МЕНЕЖЕР

О. АМАРСАНАА

"ШУНХЛАЙ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ж. МӨНХНАРАН

"СОД МОНГОЛ" ХХК-ИЙН ДЭД ЗАХИРАЛ

Н. ГАНСҮХ

"ПЕТРОВИС ОЙЛ" ХХК-ИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Н. НАСАНЖАРГАЛ